

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

### Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Палеолитын (хуучин чулуун зэвсэг) доод үед холбогдох хугацаа аль нь вэ? /1 оноо/  
A. 15.000-8.000 жил                      B. 8.000-3.000 жил                      C. 800.000-100.000 жил  
D. 800.000-15.000 жил                      E. 40.000-15.000 жил
2. Эхийн эрхт овог үүсэх болсон гол шалтгаан юу вэ? /1 оноо/  
A. Овгийн дотор эмэгтэй хүний үүрэг их, нэр хүнд өндөр байснаас  
B. Хувийн өмч бий болсноос  
C. Эрчүүд нь илүү эрх үүрэг, байр суурьтай байснаас  
D. Овгийн нэр, угийн түүхийг хадгалж байснаас  
E. Алунгоо эхийн домогт өгүүлснээр
3. Эртний хүмүүс нум сумыг хэдийд бүтээж хэрэглэсэн бэ? /1 оноо/  
A. Хуучин чулуун зэвсгийн үед                      B. Дунд чулуун зэвсгийн үед  
C. Шинэ чулуун зэвсгийн үед                      D. Хүрэл зэвсгийн үед                      E. Төмөр зэвсгийн үед
4. Хүрэл зэвсгийн бүтэц найрлагад ямар ямар металл ордог вэ? /1 оноо/  
A. Зэс, тугалга                      B. Зэс, гууль                      C. Зэс, төмөр                      D. Зэс, хөнгөн цагаан  
E. Зэс, мөнгө
5. Орхоны хөндийд байсан эртний Хүннү улсын нийслэл аль нь вэ? /1 оноо/  
A. Мөөмт хот                      B. Лүнтэн /Луут хот/                      C. Гуа дов  
D. Ордубалык                      E. Бор хот
6. Вэй улсын сударт “Анх Ливэй хааны сүүлээр үс нь хөмсгөө хүртэл ургасан бөгөөд уг, овог нэрээ мартсан нэгэн боолыг барьжээ. Түүнийг эзэн нь Мугулюй хэмээн нэрлэжээ” гэсэн байдаг. Энэ нь эртний аль улсад хамаарах эх сурвалж вэ? /1 оноо/  
A. Хүннү                      B. Сяньби                      C. Нирун  
D. Түрэг                      E. Хятан
7. “Газар бол төр, улсын үндэс мөн” хэмээх төрт ёсны зарчмыг хэн үндэслэсэн бэ? /1 оноо/  
A. Модунь                      B. Түмэн                      C. Буман                      D. Амбагян                      E. Кутулулг
8. Хянганы зүүнтээ Ляохэ гол, Шар мөрний умард саваар нутаглаж, улмаар 923 оноос Алтайгаас зүүнтээ Хэрлэн гол хүртэл нутгаа тэлсэн эртний улсыг нэрлэнэ үү. /1 оноо/  
A. Хятан улс                      B. Сяньби улс                      C. Уйгур улс  
D. Түрэг улс                      E. Хар Кидан улс
9. Энэхүү түүхэн дурсгал эртний аль улсад хамаарах вэ?

/2 оноо/

- A. Хүннү
- B. Нирун
- C. Түрэг
- D. Уйгур
- E. Хятан

10. Эргүнэ гүнгээс нүүн гарсан Дарлигин Монголчууд хаана ирж нутагласан бэ? /1 оноо/  
A. Сэлэнгийн бэлчирт                      B. Бурхан халдунд                      C. Алтайн нуруунд  
D. Далан балжудад                      E. Хангайн нуруунд
11. Хааны дараа орох тайш албан тушаалыг хэн бий болгосон бэ? /1 оноо/  
A. Амбагай                      B. Хотул                      C. Хабул  
D. Бартан баатар                      E. Даридай отчигин
12. Ираны түүхч Рашид-ад Диний зохиолд “Эргүнэ гүнгийн домог”-ийн тухай өгүүлдэг. Энэ ямар нэртэй зохиол вэ? /1 оноо/  
A. Монголын нууц товчоо                      B. Судрын чуулган                      C. Монголчуудын түүх  
D. Дорно этгээдэд зорчсон тэмдэглэл                      E. Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл
13. Хамаг Монгол, Алтан улсын хооронд 1147 онд гэрээ байгуулсныг зууны тоололд шилжүүлсэн зөв илэрхийлэл аль нь вэ? /2 оноо/  
A. XIII зуун                      B. XI зууны I хагас                      C. X зуун  
D. XII зууны I хагас                      E. Тохирох хариулт алга
14. Тэмүжин аль овгийн хүн бэ? /1 оноо/  
A. Салжиуд                      B. Элжигин                      C. Боржигин                      D. Хатигин  
E. Арулад
15. Лу. Алтан товч зохиолд тэмдэглэснээр Тэмүжин хар усан морин жилд Есүхэй баатрын эхнэр Өэлүн хатнаас мэндэлжээ. Уг газар хаана байдаг вэ? /1 оноо/  
A. Хөдөө арал                      B. Хархорум                      C. Дэлүүн болдог  
D. Алтайн нуруунд                      E. Тамирын Шар орд
16. 1225 оны эхээр Чингис хаан Хорезм зэрэг орнуудтай хийсэн аян дайнаас эх нутагтаа буцаж ирсэн байдаг. Энэ нь хэд хэдэн шалтгаантай бөгөөд түүнд үл хамаарах зүйл аль нь вэ? /2 оноо/  
A. Алтан улсыг дайлж явсан Мухулай жанжин нас барсан.  
B. Алтан улсын зарим хот Монголчуудын эсрэг боссон.  
C. Тангуд улс хүчин хавсраагүй харин эсрэг зогссон.  
D. Умард Алтан улсын нийслэл Жүндүгийн ойролцоо шинэ нийслэл байгуулах болсон.  
E. Энд тийм зүйл дурдаагүй байна.
17. Монголын нууц товчоо түүхэн зохиолд Өгөөдэй хааны 4 сайн ба 4 муу үйлийг өгүүлсэн байдаг. Сайн үйлд үл хамаарахыг нь олно уу. /2 оноо/  
A. Умард Алтан улсыг бүрэн эзэлсэн.  
B. Морин өртөөг байгуулсан.  
C. Хархорум хотын мөнгөн модыг бариулсан.  
D. Усгүй газар худаг гаргаж, хүн, малыг ундаалсан.  
E. Эзэлсэн хот, суурингуудад захирагч, даргач нарыг суулгасан.
18. “Чингисийн чулууны бичиг”-т хамаарах өгөгдөл аль нь вэ? /2 оноо/  
A. Хасарын хүү Есүнгэ мэргэн 335 алд газар онч мэргэн харвасан.  
B. Өгөөдэй хаан өртөө зам бариулсан тухай өгүүлсэн.  
C. Чингис хааны билэг сургаалаас өгүүлсэн.  
D. Мөнх хааны дурсгалд зориулан босгосон.  
E. Өлзийт хааны хаан ор суусныг тэмдэглэсэн.
19. Чингис хаан газар нутгаа дөрвөн хүүдээ хуваан өгчээ. Тарвагатайн нурууны орчмын нутгийг аль хүүдээ өгсөн бэ? /1 оноо/  
A. Зүчи                      B. Цагаадай                      C. Өгөөдэй  
D. Тулуй                      E. Борохул

20. “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх” хэмээх түүхэн зохиолыг хэн туурвисан бэ? /1 оноо/  
 А. Ата- Малик Жувейн В. Марко Поло С. Плано Карпини  
 D. Рашид- ад Дин E. В.Рубрук
21. Монгол хаадын үйл ажиллагааг дурдахдаа алдаа гаргасан бол олно уу. /2 оноо/  
 1. Чингис хаан 1220-иод онд Хархорум хотыг барих зарлиг гаргасан.  
 2. Өгөөдэй хаан Умард Алтан улсыг бүрэн эзэлсэн.  
 3. Хубилай бүх Хятадыг эзэлсэн Монгол хаан байсан.  
 4. Хүлэгү хаан Бээжинд төвлөн сууж, Хятадыг захирсан.  
 5. 1247 онд Гүюг хаан хүн амын тооллого явуулсан.  
 6. Тогоонтөмөр хаан зарлиг буулгаж, Ганжуурыг орчуулсан.  
 7. Мөнх хаан дүү Хүлэгүд цэрэг өгч, исламын улсуудыг эзлэх даалгавар өгсөн.  
 А. 1, 2 В. 2, 3 С. 3, 5 D. 4, 6 E. 7, 5
22. Ил хаадын улсын анхны нийслэл аль нь вэ? /1 оноо/  
 А. Тебриз В.Самарканд С. Хархорум D. Батын Сарай  
 E. Бээжин
23. Монголын Юан улсын Хятад дахь ноёрхол хэзээ унасан бэ? /1 оноо/  
 А. 1260 В. 1294 С. 1368 D. 1380 E. 1385
24. Хүлэгү хаан Исламын улс, Багдадын халифыг эзэлж, аль улсыг үндэслэсэн бэ? /1 оноо/  
 А. Алтан орд В. Ногайн орд С. Астраханы улс  
 D. Ил хаадын улс E. Казаны хант улс
25. Алтан ордны улсын түүхэнд хамаарах өгөгдлийг нэрлэнэ үү. /1 оноо/  
 А. Үндэслэгч нь Хүлэгү В. Сарай хот С. Самарканд  
 D. Олон хэл, угсааны хүмүүс харъяалагддаг. E. В ба D зөв.
26. “Ухаант” хэмээх Тогоонтөмөр хаан “Улаан алчууртны бослого” дэгдсэний улмаас нийслэл Дайдуг орхин Хятадаас хэдэн онд зугтан гарсан бэ? /1 оноо/  
 А. 1368 В. 1370 С. 1454 D.1634 E. 1640
27. Монголын эзэнт гүрний үед “40 түмэн монгол, 4 түмэн ойрад” хэмээн нэрлэдэг байсан бол бутралын үед ..... гэж нэрлэх болсон. /2 оноо/  
 А. 40 түмэн Монгол, 4 түмэн Ойрад В. 6 түмэн Монгол, 4 түмэн Ойрад  
 С. 10 түмэн Монгол, түмэн Ойрад D. 3 түмэн Халх, 1 түмэн Ойрад  
 E. Хамаарах өгөгдөл алга
28. Монголд олон жил үргэлжилсэн бутрал, дайн дажин дөч гаруй жил намжсан Батмөнх Даян хааны үеийг сурвалжид хэрхэн тэмдэглэдэг вэ? /2 оноо/  
 А. “Гар газар, хөл хөсөр” үе В. “Дөчин дөрвөн хоёр нэг хааны алдар болов”  
 С. Бага хаадын үе D. Бутралын үе E. Нэгдмэл үе
29. Түмэн хаан зүүн, баруун түмний түмэн бүрээс хамгийн нэр хүндтэй, нөлөө бүхий хан, ноёдыг оролцуулан “Төв Засгийн газар” байгуулсан байдаг. Түүхэнд ямар хаан гэж алдаршсан бэ? /1 оноо/  
 А. Даян хаан В. Хутагт хаан С. Жонон хаан D.Засагт хаан  
 E. Үхэгт хаан
30. Улс төрийн бутралын үед хэн, хэн шарын шашныг хаана дэлгэрүүлсэн бэ? /2 оноо/  
 А. Автай сайн хан 1. Халх  
 В. Зая бандид Намхайжамц 2. Ойрад  
 С. Алтан, Хутагтай сэцэн хунтайж 3. Түмэд ба Ордос  
 А. a1, b2, c3 В. a1, b3, c2 С. a2, b1,c3 D. a2, b3, c1  
 E. a3, b1, c2

31. 1636 онд Өвөр Монголын 16 аймгийн 49 хошууны ноёдын чуулган болж, Өвөрмонгол Манжид дагаар орсон. Аль чуулган бэ? /2 оноо/  
 А. Мүгдэний чуулган  
 В. Ширээ цагаан нуурын чуулган  
 С. Тарвагатайн Улаан бураагийн чуулган  
 D. Ар Элстэйн чуулган  
 E. Долнуурын чуулган
32. “Миний нутгийн газар шорооноос бурхан гуйсан ч бүү өг” гэж хэн хэлсэн бэ? /1 оноо/  
 А. Галдан бошигт В. Чингүнжав С. Амарсанаа  
 D. Лигдэн хутагт E. Цэвээнравдан
33. Лигдэн хааны түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, үйл ажиллагаанд хамаарахгүй өгөгдлийг олно уу. /2 оноо/  
 1. 1617 онд “Очир цагаан” хот байгуулав.  
 2. Дуутын хадны бичээс  
 3. Чингис ба Хубилай хааны номын цолыг хамтатган хэрэглэв.  
 4. Ганжуур 108 ботийг 33 эрдэмтнээр орчуулсан.  
 5. Улааны шашны лам Шарваа хутагтыг “Улсын багш” болгов.  
 6. Халх, Өвөр, Баруун Монголыг нэгтгэсэн Их Монгол улс байгуулав.  
 А. 2,6 В. 1,3 С. 3,5 D. 4,5 E. 1,5
34. Манжийн захиргааны хэрэгт хүчин зүтгэдэг дээд давхарга аль вэ? /1 оноо/  
 А. Суман эр В. Хамжлага ард С. Шавь ард  
 D. Лам ард E. Ноёд, язгууртнууд
35. Манж жанжин, сайдын газар, аймаг, хошуудыг хооронд нь холбосон орон нутгийн өртөөдийг ..... гэдэг. Нөхнө үү. /2 оноо/  
 А. Харуул цэргийн алба В. Суман харуул С. Гэр харуул  
 D. Суман өртөө E. Дотоод харуул
36. Дараах түүхэн үйл явдлуудыг түүхэн зүй тогтлоор нь зөв дараалалд оруулна уу. /2 оноо/  
 1. Манжийн амбан сайд Сандог Хүрээнээс гарах шаардах бичиг өгсөн.  
 2. VIII Богд Живзундамба хутагтыг хаанд өргөмжлөх ёслол болсон.  
 3. Сандог Хүрээнээс хөөсөн.  
 4. Улсын дээд, доод хурал байгуулсан.  
 5. Хиагтын гурван улсын гэрээ байгуулагдсан.  
 А. 1, 3, 2, 4, 5 В. 1, 2, 3, 4, 5 С. 5, 4, 3, 2, 1  
 D. 3, 5, 1, 2, 4 E. 3, 1, 5, 4, 2
37. 1911 оны 12 сарын 29-ний өдөр 11 цагт VIII Богдыг залж, улмаар таван яамыг байгуулсан. Төрийн яамд ба сайдуудыг харгалзуулна уу. /2 оноо/  
 А. Дотоод яам 1. Цэрэнчимэд  
 В. Гадаад яам 2. Ханддорж  
 С. Сангийн яам 3. Чагдаржав  
 D. Цэргийн яам 4. Гомбосүрэн  
 E. Шүүх яам 5. Намсрай  
 А. а5, b4, c3, d2, e1 В. а5, b4, c3, d1, e2 С. а2, b5, c3, d1, d4  
 D. а2, b4, c5, d1, e3 E. а1, b2, c3, d4, e5
38. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал нь Монголын уламжлалт тооллоор ямар жилд өрнөсөн бэ? /1 оноо/  
 А. Цагаагчин гахай жил В. Цагаан морин жил С. Хөхөгчин тахиа жил  
 D. Улаан барс жил E. Хар морин жил

39. Консулын дэнжийн бүлгэмийн гишүүдэд аль өгөгдөл хамаарах вэ? /1 оноо/  
А. С.Данзан, Д.Догсом  
В. Д.Бодоо, Д.Чагдаржав  
С. Д.Сүхбаатар, Ө.Дэндэв  
D. Д.Лосол, Х.Чойбалсан  
E. В ба D хамаарна.
40. Ардын намын цэрэгт Хиагтын зүүнтээх нутгаас элссэн хүмүүсийг ямар цэрэг гэж нэрийддэг байсан бэ? /1 оноо/  
А. Шадар цэрэг  
В. Цахар цэрэг  
С. Цоохор цэрэг  
D. Хошуу цэрэг  
E. Хиагт цэрэг
41. Оросын Троицкосавск хотноо хамтарсан зөвлөгөөн хэзээ болсон бэ? /Намын анхдугаар их хурал/ /1 оноо/  
А. 1921. 3.1-3  
В. 1921. 3.13  
С. 1921. 3.18  
D. 1921. 7.6  
E. 1921. 7.10
42. 1923 оны 3 сарын 23-нд “Монгол улсын нутгийн захиргааны дүрэм”-ийг баталсан. Сайн ноён хан аймгийг хэрхэн нэрлэж байсан бэ? /1 оноо/  
А. Хан Хэнтий уулын аймаг  
В. Хантайшир уулын аймаг  
С. Богд хан уулын аймаг  
D. Цэцэрлэг мандал уулын аймаг  
E. Чандмань уулын аймаг
43. “... Хэмжээт эрхтэй хаант засаг бол хуучнаас шинэ байгуулалд шилжих үед зайлшгүй байх ёстой засаглалын хэлбэр. Ардын нам улаан Оросоос тусламж гуйсан нь зөв болсон юм. Харин дотоод бодлогодоо улаан Оросыг дуурайх нь буруу...” гэсэн Д.Бодоогийн үзэл байдаг. Дээрх түүхэн баримтын агуулгатай нийцүүлэн хийсэн дүгнэлтэд аль нь хамаарах вэ? /2 оноо/  
А. Хэмжээт эрхт хаант засаг одоохондоо байх ёстой.  
В. МАН Зөвлөлт Орос улсаас тусламж гуйсан нь зөв байсан.  
С. Оросоос тусламж гуйсан нь тэднийг дагаж хуулбарлана гэсэн үг биш юм.  
D. Шилжилтийн үед хэмжээгүй эрхт хаант засаг зохистой.  
E. А, В, С хамаарна.
44. “Баруунтныг илчлэх ажлаа түргэсгэж, асуудалд хариуцлагатай хандахтун, та бүхэн арав хоногийн дараа нам, төрийн жолоог атгана” гэж зүүнтнүүдийг турхирч байсан хүн хэн бэ? /1 оноо/  
А. М.Амагаев  
В. Ц.Дамбадорж  
С. Н.Жадамба  
D. Г.Гэлэгсэнгэ  
E. Ж.Цэвээн
45. 1932 оны 6 сарын 29-30-нд МАХН-ын ТХ, Намын хянан байцаах төв комиссын хамтарсан онц III бүгд хурлаар намаас гаргасан алдаануудыг тодорхойлж, цаашдын зорилтуудыг тодорхойлсныг түүхэнд ..... гэж нэрлэдэг. /2 оноо/  
А. Онцгой бүрэн эрхт комисс  
В. Улсын онц эрх  
С. Шинэ засгийн бодлого  
D. Шинэ эргэлтийн бодлого  
E. Тохирох хариулт алга.
46. 1932 онд зэвсэгт босогчид “шашныг мандуулж, амьтныг жаргуулагч Очирбатын цэргийн яамнаас Хялганат зэрэг хойд талыг тохинуулахаар тусгайлан томилогдсон” хэн гэгчийн бичгийг авч явсан бэ? /1 оноо/  
А. Шарын бичиг  
В. Самбуугийн бичиг  
С. Түгж жанжны бичиг  
D. Илбэн тохинуулах бичиг  
E. Тангарагийн бичиг
47. “Онцгой бүрэн эрхт комисс” байгуулагдаж, хууль ёс, төрд захирагдахгүй, онцгой эрх дархтай, ажиллаж эхэлсэн цаг хугацаа аль вэ? /1 оноо/  
А. 1934. 7.27  
В. 1937. 10.18-21  
С. 1937. 10.2  
D. 1936. 03.12  
E. Эдгээрээс өөр

48. Халх голын дайн хэзээ дууссан бэ? /2 оноо/  
А. 1936 оны 3 сарын 12-нд БНМАУ, ЗСБНХУ-тай “Харилцан үл довтолох гэрээ” байгуулснаар  
В. 1939 оны 8 сарын 23-нд Герман,ЗХУ-тай “Харилцан үл довтолох гэрээ” байгуулснаар  
С. 1939 оны 8 сарын 31-нд Японы квантуны 6-р армийг эх нутгаасаа хөөж гаргаснаар  
D. 1939 оны 9 сарын 16-нд ЗСБНХУ-ын комиссар В.Молотов, Москвад суух Японы элчин сайд С.Того нар гэрээ байгуулснаар  
E. Тохирох хариулт алга.
49. “Бэлэглэлийн төв комисс” байгуулагдаж, улмаар 1943 оны эхээр Т-34, Т-70 маркийн 53 шинэ танк бүхий цувааг улаан армид шилжүүлэн өгсөн. Аль өгөгдөлтэй нь хамаарах вэ? /2 оноо/  
А. Хувьсгалт Монгол В. Монгол ард С. Улсын онц эрх  
D. Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл  
E. Эдгээрээс өөр
50. 1949 онд НТХ-оос “БНМАУ-ын түүх, утга зохиолыг дунд сургуулиудад зааж байгаа байдлын тухай”, “Ардын унших бичгийн тухай” зэрэг тогтоолуудад Х.Пэрлээ, Б.Ринчен, Ш.Нацагдорж зэрэг сэхээтнүүдийг хэрхэн буруутгасан байдаг вэ? /2 оноо/  
А. Үндэсний явцуу үзлийг номлосон.  
В. Чингис хааныг магтсан.  
С. Чингис хааны түрэмгийлэх дайнд марксист бус дүгнэлт өгсөн.  
D. Ангич, намч бус байр суурь баримталсан.  
E. Дээрх бүгд
51. Монгол улсын Үндсэн хуулинд эдийн засаг, нийгмийг улсын төлөвлөгөөний үндсэн дээр хөгжүүлэх зарчмыг тогтоож, анх удаа МАХН-ын “улс нийгмийн бүх байгууллагуудыг удирдан чиглүүлэх” үүргийг хуульчлан тогтоожээ. Энэ заалт аль Үндсэн хуульд байдаг вэ? /2 оноо/  
А. 1924 оны Үндсэн хууль В. 1940 оны Үндсэн хууль  
С. 1960 оны Үндсэн хууль D. 1992 оны Үндсэн хууль  
E. Намын IV программ
52. Социализмын үеийн нийгмийн улс төрийн хүрээн дэх онцлог шинжүүдийг дурдахдаа алдаа гаргасан бол олно уу. /2 оноо/  
А. Эрх баригч нэг намын систем  
В. Нам төвтэй улс төрийн тогтолцоо  
С. Сонгууль бэлгэдэл төдий, альтернатив зарчим алдагдсан.  
D. Олон ургальч үзлийг хөхиүлэн дэмждэг.  
E. Тохирох хариулт алга.
53. “Мандухай сэцэн” нэртэй түүхэн кино зохиолыг хэн туурвисан бэ? /1 оноо/  
А. Ч.Лодойдамба В. Ш.Нацагдорж С. Л.Түдэв  
D. С.Удвал E. Д.Намдаг
54. 1990 оны 3 сарын 7-ны өдрийн 14 цагт ямар түүхэн үйл явдал болсон бэ? /2 оноо/  
А. Монголын ардчилсан холбоо байгуулагдсанаа зарласан.  
В. Монголын ардчилсан холбооны 10 гишүүн, нийт 30 гаруй хүн оролцсон анхны улс төрийн өлсгөлөн Сүхбаатарын талбайд болсон.  
С. Нам, төрийн удирдлага ба шинэ хүчний удирдагчдын оролцсон “Дугуй ширээний ярилцлага” болсон.  
D. Ардчилсан шинэ Үндсэн хуулийг баталсан.  
E. Анхны чөлөөт, ардчилсан сонгууль явагдсан.
55. 1991 оны Засгийн газрын 30-р тогтоолоор хийгдсэн өмч хувьчлал ямар хоёр хэлбэртэй явагдсан бэ? /2 оноо/  
А. Бага хувьчлал В. Их хувьчлал С. Үнэт цаасны хувьчлал  
D. В ба С E. А ба В

56. Монгол улсын шинэ Үндсэн хуулинд төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг хэрхэн тодорхойлсон бэ? /2 оноо/
- A. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх
  - B. Хүмүүнлэг, иргэний ардчилсан
  - C. Тунгалаг хариуцлагатай, нээлттэй, ил тод
  - D. Иргэний, ардчилсан хүмүүнлэг
  - E. Тохирох хариулт алга.

### ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ, ДАРААЛАЛ СЭРГЭЭХ ДААЛГАВАР

Санамж:

1. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.
2. Зөв хариулт бүр нэг оноотой.

- 2.1. Монголын түүх, археологийн дараах дурсгалууд олдсон газрыг одоогийн аймаг, нутгаар нь тохируулан нэрлэнэ үү. /5 оноо/

- A. Нарийн гол 17Б бууц /палеолит/
- B. Тамсагбулагийн суурин /неолит/
- C. Ноён уулын язгууртны булш /Хүннү/
- D. Культегиний гэрэлт хөшөө /Түрэг/
- E. Долоодойн булшны гэрэлт хөшөө /Уйгур/

- 2.2. Дараах ойлголтуудыг түүхэн утгаар нь зөв харгалзуулна уу. /5 оноо/

- |                    |   |
|--------------------|---|
| A. Хадны сүг зураг | 1. Орчин үеийн дугуйт техникийн үүсвэр болсон.            |
| B. Хиргисүүр       | 2. Толгойг нь зүүн зүг хандуулж, тэнэгэр байдлаар тавина. |
| C. Буган хөшөө     | 3. Дэлхийд 700 орчим олдсоноос Монголд 550 нь бий.        |
| D. Дөрвөлжин булш  | 4. Оршуулгын байгууламж төдийгүй тахилгын газар.          |
| E. Морин тэрэг     | 5. Зосон ба сийлмэл аргаар бүтээдэг.                      |

- 2.3. Монгол нутагт оршиж байсан эртний улсуудын хаадыг амьдарч байсан он цагийн дарааллаар нь эрэмбэлнэ үү. /1-5 хүртэл дугаарлана./ /5 оноо/

- A. Шэлүнь .....
- B. Амбагян .....
- C. Можа .....
- D. Модунь .....
- E. Пэйло .....

- 2.4. Дараах түүхэн үйл явдлуудыг цаг хугацаатай нь зөв харгалзуулна уу. /5 оноо/

- |  |                 |
|--|-----------------|
| A. “Билэгт” хэмээх Аюушридар хаан суув.                            | 1. 1449 он      |
| B. Эсэн тайш Мин улсыг довтолж, эзэн хаан Ин-Зуныг олзлов.         | 2. 1577 он      |
| C. Түмэдийн Алтан хан Төвөдийн Содномжамцад “Далай лам” цол олгов. | 3. 1370-1378 он |
| D. Автай сайн хан Эрдэнэзуу хийдийг байгуулав.                     | 4. 1639 он      |
| E. Занабазарыг анхдугаар Богдоор өргөмжлөв.                        | 5. 1586 он      |